



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 2/3

Номгон

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 “д” заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

116019

Аймгийн ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн
2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
II хуралдааны 2/3 тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

ЭРХЭМ ЗОРИЛГО: Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон, эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлал хосолсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн, хүний болон эдийн засгийн хөгжлөөрөө Монгол Улсын тэргүүлэх аймгуудын нэг болно

НЭГ.ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

А. Хүний хөгжил

Зорилго: “Баянхонгорын иргэд - Баянхонгорын баялаг” зарчмыг удирдлага болгож, иргэдээ бүх талаар системтэй хөгжүүлнэ.

1.Иргэддээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрөлжсөн богино хугацааны сургалтуудыг аймгийн Политехникийн коллеж, Өлзийт МСҮТ, “Ажилсаг төв”-ийг түшиглэн зохион байгуулна.

2.Насан туршийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, иргэдээ аж ахуй эрхлэх, амьдрах арга ухаан, эрүүл аж төрөх дадал хэвшилд сургаж, сонирхсон чиглэлүүдээр нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгон ирээдүйдээ итгэх итгэл, баялаг бүтээх сэтгэхүйтэй болгож, гадаад хэлний зохих мэдлэг, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг амьдрал ахуйдаа ашиглаж сурах боломжийг бүрдүүлнэ.

3.Иргэн бүрийн аймгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах болслцоо нөхцөлийг бүрдүүлж, тэдний гаргасан “Шилдэг бүтээл, дэвшилтэт технологи, оновчтой санал”-ыг үнэлж, төрөөс худалдан авч урамшуулах тогтолцоог бий болгон, “Шилдэг бүтээл, оновчтой санал” (ШБОС)-ын уралдааныг аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулж, шалгарсан бүтээлийг бодлогоор дэмжиж үндэсний болон гадаадын зах зээлд гаргах, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд нь туслана.

4.Хүн амын бүлгүүдийг дэмжсэн хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлж нийгмийн бүлгүүд болон ажил мэргэжлийн чиглэлүүдээр иргэдийг зохион байгуулалтанд

оруулж, өөр өөрсдийн чиглэлээр аймаг, орон нутгийн хөгжлийн бодлого тодорхойлоход оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж аймаг, орон нутгийн хөгжилд идэвхи, санаачилгатай оролцуулах бодлого барина.

5. *Хувилбар 2.* Ажил мэргэжлийн уралдаануудыг зохион байгуулж шилдгүүдийг алдаршуулах, гадаад, дотоодод мэргэжил ур чадвараа дээшлүүлэх, туршлага судлахад нь дэмжлэг үзүүлж, зөвлөх мэргэжилтнүүдийг урьж дагалдуулах замаар хөгжүүлнэ.

6. **“Шинэ хөдөө”** хөтөлбөр хэрэгжүүлж хөдөөгийн ард иргэдээ хөгжүүлнэ.

7. Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, төр, олон нийтийн байгууллагуудад жендерийн зохистой харьцааг буй болгон аливаа удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн ажиллах боломжийг бий болгоно.

8. *Ахмад настнуудын* ажил амьдралын баялаг туршлагыг бусдад өвлүүлэн сургах зорилго бүхий **“Ахмадын зөвлөх үйлчилгээний төв”**-ийг байгуулан хамтран ажиллана.

9. Бичил уурхайчид болон ХАМО иргэдийн мэдээллийн цахим сан үүсгэн, экологийн боловсрол олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгож мэргэжил эзэмшүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх санал, санаачлагыг дэмжих чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

Б. Боловсрол

Зорилго: Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг тэргүүлэх аймгуудын хэмжээнд хүргэхийг зорино.

10. Хүүхэд харах үйлчилгээг дэмжиж, шинээр цэцэрлэг барих, шаардлагатай цэцэрлэгүүдийн байрыг өргөтгөх, иргэд, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн сургууль цэцэрлэг байгуулах асуудлыг бодлогоор дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт 100 хувь хамруулна.

11. Хүүхдийг цэцэрлэгээс эхлэн авъяас чадварыг нээхэд нь туслах зорилгоор хүүхдийн ухаан сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэгдсэн **“Үндэсний онцлогтой тоглоом”**-ын үйлдвэр байгуулж, аймгийн бүх цэцэрлэгийг хангана.

12. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулиудын багш нарын мэргэжил, авъяас, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх зорилгоор жил бүр шалгаруулалт явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тогтвор суурьшилтай ажиллуулах **“Сайн багш”** хөтөлбөр хэрэгжүүлж, 100- аас доошгүй багшийг

гадаадад давтан сургаж, жилд 10 сая хүртэл төгрөгийн эх үүсвэр бүхий санг бий болгож урамшуулна.

13.Аймгийн төвийн 5 дугаар сургуулийг ашиглалтад оруулж, 6 дугаар сургуулийг барьж, бусад шаардлагатай сургуулиудын хичээлийн байруудыг өргөтгөх, шинээр барих замаар сургуулиудын ээлжийн коэффициентийг бууруулж, 1 ангид суралцах хүүхдийн тоог 30-аас ихгүй болгоно.

14.Шаардлагатай сургуулиудад сурагчдын дотуур байр шинээр барих, засварлах, өргөтгөх ажлыг зохион байгуулна.

15.Хүүхэд бүрийг уламжлалт өв соёлд сургах, хөдөлмөр эрхлэх дадал хэвшил, өв тэгш хүмүүжил, төлөвшилтэй болгох зорилгоор **“Хүүхдийн амьдрах ухааны төв-зуслан”**-г сургуулиудыг түшиглэн байгуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулах замаар ажиллуулна.

16. Авъяас хөтөлбөрийг үргэлжлүүлэн хүүхдийн техник сэтгэлгээ, оюун ухааныг хөгжүүлэх **“Өсвөрийн зохион бүтээгч”** клубыг сургууль бүрт байгуулж, **“Робокон-Баянхонгор”** тэмцээнийг жил бүр зохион байгуулна.

17.“Сурагч бүр сурах бичигтэйгээ” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

18.Боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, хүн амын боловсролын түвшинг ахиулах, орон нутгийн энцлогт тулгуурлан хүүхдийн авъяас чадварыг багаас нь хөгжүүлж хүсэл сэнирхолынхоо дагуу боловсрол олоход нь Политехникийн коллежийн дэргэдэх амьдралын чиг баримжаа олгох төвийн үйл ажиллагааг чиглүүлж хүүхдийг амьдрал, хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн чиг баримжаа олгох ЕБС-ийн ахлах сургуулиудын хэв шинжийг оновчтой тогтоож хэрэгжүүлнэ.

19.Биеийн тамир спортын төрөлжсөн дунд сургуулийг байгуулна.

20.Аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах зорилго бүхий **“Хүний нөөцийн хөтөлбөр”** хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд аймаг орон нутгийн захиалгат мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудыг **“Боловсролын зээлийн сан”**-д хамруулж, **“Сургууль-Захиалагч-Оюутан-Орон нутгийн төрийн байгууллага”**-ын 4 талт гэрээ байгуулан төгсөгчдийг найдвартай ажлын байраар хангана.

21.Баянхонгор аймгаас Улаанбаатар хотод суралцаж буй оюутнуудын амьдрах орчныг сайжруулах зорилготой **“Баянхонгорын оюутны байр”** төслийг иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

22.Өөрийн онцгой авъяас ур чадвараа хүүхэд залуучуудад өвлөн уламжлуулдаг **“Багш-Шавь-Багш”** уламжлалыг сэргээж, шавь сургалт зөхион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн иргэнийг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

23.Монгол бичиг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, **“Хос бичигтэн аймаг”** болох хөдөлгөөн өрнүүлнэ.

24.Англи хэл, Орос хэл, Хятад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай ангиудыг ЕБС-иудад нээж, мэргэжилтэн, багш нарыг урьж ажиллуулна.

25.Сургууль бүрийн байгалийн ухааны төрөлжсөн кабинетуудыг шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжүүдээр ханган, бага ангийн хүүхдүүдэд байгалийн юмс, үзэгдлүүдийг бодитоор тайлбарлан таниулах лабораториуд байгуулж, багш нарыг энэ чиглэлээр сургаж дадлагажуулна.

26.Өвгөнжаргалантын хүүхдийн зусланг өндөр хүчдэлийн шугаманд холбож, тохижуулна.

В. Эрүүл мэнд

Зорилго: Хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлийг багасгаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэхийг зорьж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлнэ.

27.Хүн амын өвчлөлт, нас баралтад нөлөөлж буй дотоод хүчин зүйл болох амьдралын буруу хэвшил дадал, гадаад хүчин зүйл болох усны хатуулаг, агаар болон хөрсний бохирдол, осол гэмтлийг бууруулах чиглэлээр судалгаанд суурилсан дэс дараатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

28.Элэгний С вирусын тархалтыг бууруулах **“Элэг бүтэн-Баянхонгор”** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

29.“Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадал хэвшлийг иргэдэд төлөвшүүлэх ажлыг бүх нийтийн хүртээл болгох зорилгоор **“Эрүүл байгууллага”**, **“Эрүүл сум”** болзолт уралдааныг аймгийн хэмжээнд өрнүүлэн жил бүр шалгаруулж, шагнаж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

30.Төвлөрсөн газруудын ундны усны хангамжийг нэмэгдүүлж, худгуудад ус цэвэршүүлэгч байрлуулна.

31.Агаар, хөрсний бохирдлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

32.“Идэвхтэй хөдөлгөөн-урт нас” аян өрнүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцүүдийг бий болгоно.

33.Аймгийн хэмжээнд эм эмнэлгийн бүтээгдэхүүнийг ижил үнээр худалдаалах нөхцлийг бүрдүүлж эм бэлдмэлийн чанар стандартыг хатуу мөрдүүлнэ.

34.Шаардлагатай сумдад *өрхийн* эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барих, засварлах, өргөтгөх ажлыг зохион байгуулж, уламжлалт эмчилгээний болон, эмчилгээний дараах сэргээн засах тасгуудыг бий болгоно.

35.Аймгийн нэгдсэн эмнэлгийг зөөврийн рентгейн болон томографийн аппаратаар хангаж, хүүхдийн эмнэлгийн барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна.

36.Эрүүл мэндийн салбарын тогтолцооны гажуудлыг арилгах, тэдэнд ээлтэй орчин бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий **“Эмч, эмнэлгийн ажилтан”** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

37.Малчид болон алслагдсан бүс нутагт ажиллаж амьдарч буй иргэдэд үйлчлэх иж бүрэн явуулын амбулаторийг бий болгож, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоог багийн түвшинд давтамжтайгаар хэрэгжүүлнэ.

38.Хүн амын тоотой уялдуулан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог зохистой түвшинд хүргэж, тэдгээрийн ажлын ачааллыг бууруулан, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, цалин урамшууллын системийг бодит ачаалалтай уялдуулан шийдвэрлэх бодлого баримтална.

39.Аймгийн төвд уламжлалт эмчилгээ, үйлчилгээний төв байгуулж, Их, Бага Шаргалжуут, Өхөг, Өргөөт, Халиут зэрэг халуун, хүйтэн рашаан, Холбоолж нуур болон Үүдийн нуурын давс, шаврын эмчилгээний орд газар, говийн элсийг түшиглэн ингэний ундаа, гүүний айраг, саам, эмийн ургамлыг ашиглан уламжлалт эмчилгээний сувилал байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

Г. Соёл урлаг, спорт

Зорилго: Соёл урлаг, биеийн тамир спорт нь хүний хөгжлийн чухал хүчин зүйл хэмээн үзэж бүх талаар дэмжиж хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

40.Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж, соёл урлагийн үйлчилгээг явуулын машинтай болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

41.Жилд 5-аас доошгүй сумдын соёл, урлагийн өдрүүдийг аймагт зохион байгуулж ардын авьяастнуудыг нийтэд сурталчилж, алдаршуулна.

42.Соёлын өзийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

43.Соёлын салбарын байгууламж, техник технологийн шинэчлэл, инновацийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжтэй кино театр, бүжгийн заал бүхий соёлын төвийг *аймгийн төвд* шинээр байгуулна.

44.Аймаг, сумын музей дэх хосгүй үнэт үзмэрүүд, түүх соёлын үнэт өвүүд, алдартай хүмүүсийн бүтээлүүдийг гадаад, дотоодод сурталчилан таниулж, аймгийн хэмжээний **“Соёл урлагийн их наадам”**-ыг 2 жилд 1 удаа зохион байгуулна.

45.Шаардлагатай сумдад соёлын төвийн барилгыг шинээр барьж, царцаасан барилгын ажлыг дуусгана.

46.Үндэсний спортыг хөгжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

47.Биеийн тамир, спортын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг үр дүнгээр санхүүжүүлэн урамшуулах механизмыг бий болгож, улс, бүс, олон улс, тив дэлхийн чанартай тэмцээнд оролцох тамирчид, багш, дасгалжуулагчдад зардал олгох, амжилт гаргасан тохиолдолд урамшуулах тогтолцоог боловсронгуй болгон мөрдөж, тамирчдыг аж ахуйн нэгжүүдийн харьяалалд оруулж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

48.ЕБС-иудыг түшиглэн гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбай бүхий биеийн тамир, спортын иж бүрэн талбайг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр байгуулна.

49.Өвлийн спортыг хөгжүүлэх, материаллаг баазыг бий болгох цогц бодлого хэрэгжүүлнэ.

50.Сум бүр явган, уулын, унадаг дугуйн, ердийн хөсгийн аялалын маршрут гарган, гүйлт, цана, тэшүүрээр хичээллэх орчинг бий болгож, чөлөөт цагаараа бие бялдараа хөгжүүлэх, амрах нөхцөлийг бүрдүүлнэ.

51.“Их спорт”-ын бэлтгэл, сургуулилтын зориулалттай спортын цогцолборыг байгуулах, хувийн хэвшилд биеийн тамир, спортын материаллаг баазаа сайжруулахад нь дэмжлэг үзүүлнэ.

52.Шаардлагатай сум, багуудад спорт заал барьж ашиглалтанд оруулах, засварлах, техник тоног хэрэгслэлийг шинэчлэх ажлыг зохион байгуулна.

53.Соёл урлаг, спортын шилдэг ажилтан мэргэжилтнүүдийг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, орон нутагт ажиллуулах бодлого хэрэгжүүлнэ.

54. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх санал санаачилгыг идэвхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, их спортын хөгжлийг дэмжиж, “Баянхонгорын бага олимп” спортын наадмыг 4 жил тутамд зохион байгуулна.

Д. Нийгмийн халамжийн салбар

Зорилго: Хүний хөгжлийг дээдэлсэн, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн нийгмийн халамжийн оновчтой бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

55. Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох асуудлыг иргэдэд чирэгдэл төвөггүй болгох бодлого зохион байгуулалтын арга хэмжээ авна.

56. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлж тэдэнд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх тусгай журам гаргаж хэрэгжүүлнэ.

57. Ахмад өндөр настангуудаа халамжлах, сэтгэл хангалуун өөдрөг байлгах зорилго бүхий “**Ахмадаа ачлая**” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

58. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрөө хорших, хамтран үйлдвэр үйлчилгээ эрхлэх асуудлыг төрийн бодлогоор дэмжиж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлнэ.

59. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээг үзүүлдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

60. Өрх толгойлсон эцэг, эхэд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

61. Өрх толгойлсон болон бага орлоготой өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж, “**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв**” -ийг байгуулна.

62. “Ахмадын асрамжийн төв”-ийн барилгад засвар тохижилт хийж, ая тухтай орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ ахмадад үйлчлэх зориулалттай “Ахмадын амралт сувилалын газар” байгуулах асуудлыг бодлогоор дэмжинэ.

63. Малчдын тэтгэврийн насыг наашлуулах, НДШ-ийг нөхөн төлүүлэх асуудлыг хууль санаачлагчдад тавьж шийдвэрлүүлнэ.

64. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр хамрагдагчдын тоог одоогийн түвшинээс 20 хувь нэмэгдүүлнэ.

65. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

66. Нийгмийн 3 талт зөвшил хэлэлцээрийг байгуулан хэрэгжилтийг тооцож орон нутгийн хөгжилд төр, үйлдвэрчний байгууллага ажил олгогчдын орслцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГО

ЗОРИЛГО: Бүс нутгийн хэрэглээг хангахад чиглэгдсэн томоохон үйлдвэрүүдийг байгуулах, импортыг орлосон, гадаад зах зээлд чиглэгдсэн, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэн үйлдвэржилтийн хувьсгал хийж, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2 дахин өсгөж, 2000-аас доошгүй иргэнийг тогтвортой байнгын шинэ ажлын байраар хангаж, ядуурлыг 2 дахин бууруулна.

67. Баянхонгор аймгийн хүний болон түүхий эдийн нөөц, судалгаанд үндэслэн **“Аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого”** боловсруулж хэрэгжүүлнэ.

68. Малчид, жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ХЗХ-г тэдгээрийн хувь орслцоотойгоор байгуулж, банк санхүүгийн байгууллагын хамгийн оновчтой тогтолцоог бий болгон “Баянхонгор” хөгжлийн банкны суурийг тавина.

69. Иргэн, айл өрх бүр хуримтлалтай болж эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлэх, улмаар мөнгөн урсгалыг дотоодоо хадгалан өрх, аймаг орон нутгийн эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх **“Хуримтлалтай хонгорчууд”** төслийг хэрэгжүүлнэ.

70. Аймагтаа үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний зах зээлийг татвар, санхүүгийн бодлогоор хамгаалж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжиж, тууштай хөгжүүлнэ.

71. Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдийг **“Ажилсаг төв-үйлдвэр технологийн парк”**-ийн Бизнес инкубаторын төвөөр дамжуулан бойжуулах, шинэ дэвшилтэт болон өндөр технологи нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гадаад зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад нь дэмжлэг үзүүлнэ.

72. Аймгийн үйлдвэржилтийн бодлогоор тодорхойлогдсон, зорилтот зах зээлд чиглэгдсэн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд аймаг, орон нутгаас хөрөнгө оруулалт хийх, ажиллагсадын өмч, хөдөлмөрийн харилцаанд эзний сэтгэл бий болгох, иргэдээ өмчтэй болгох зорилгоор анхны хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа компаний хувьцааг ажиллагсдад нь үнэгүй хувьчлах эрх зүйн орчныг бий

болгон хэрэгжүүлж, орон нутгийн өмчийн “Чандмань Баянхонгор”, “Баянхонгор Эрчим хүч” ЦТ ХХК-иудыг хувьцаат компани болгоно.

73.Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн хариуцлагыг тодорхой болгэж, **“Нэг уурхай-нэг үйлдвэр”** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

74.Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, нэр төрөл, хүчин чадлыг зах зээлийн эрэлттэй уялдуулан өргөтгөх бодлого баримтална.

75.Цементний үйлдвэр байгуулж, орон нутгийн болон баруун бүс нутгийн хэрэгцээг хангана.

76.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг эргэлтэнд оруулж, керамик, полимер чулуун эдлэлийн үйлдвэр байгуулж бүс нутгийн хэрэгцээг хангах.

77.Нар салхины болон газрын гүний дулааныг ашиглах судалгаа хийж, **“Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэр”** байгуулах ТЭЗҮ-г боловсруулна.

78.**“24428 үйлдвэр”** төслийн хүрээнд **“Айл хотоороо үйлдвэрлэгч”** аян өрнүүлж бага оврын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг тэдэнд лизинг, бартерын аргаар нийлүүлнэ.

79.Баянхонгор сум болон бүсийн төв сумдад мах боловсруулах үйлдвэр байгуулж, хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох замаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

80.Ноос, ноолуур угаах, анхан шатны боловсруулалт хийж экспортлох жижиг, дунд үйлдвэрийг байгуулна.

81.Аймгийн хэмжээнд байнгын шинэ ажлын байр бий болгосон үйлдвэрлэгчдийг хөнгөлөлттэй зээл, төслөөр дэмжинэ.

82.Аймагтаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах **“Баянхонгорт үйлдвэрлэв”** худалдааны сүлжээ дэлгүүрүүдийг Улаанбаатар хот болон бусад төвлөрсөн газарт нээнэ.

83.**“Нэг сум, нэг байгууллага-нэг шилдэг бүтээгдхүүн, үйлчилгээ”** хөдөлгөөн өрнүүлж сум, байгууллага бүр брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээтэй болно.

84.Улаанбаатараас баруун аймгийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замын дагуу олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний иж бүрэн төвүүдийг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулж тухайн бүс нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх **“Баруун зам”** төслийг хэрэгжүүлнэ.

85.Их, бага Богд уул, Шаргалжуутын халуун рашаан, хангай тал хээр, говийн үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газар, байгалийн гурван бүс нутгийн

онцлог, нүүдлийн уламжлалт соёлыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой **“Аялал жуулчлалын алба”**-ыг аймгийн Засаг даргын дэргэд байгуулж, аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

86.Архангай аймагт ирсэн аялагчдыг Хөл сая, Эгийн даваагаар аймгийнхаа хангайн чиглэлийн маршруттай холбох, Өвөрхангай аймагт ирсэн жуулчдыг Найман нуураас Элбэхийн даваагаар Шаргалжуутын маршруттай холбох, Шаргалжуутад аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Өмнөговь аймагт ирсэн аялагчдыг говийн маршруттай холбох стратегийг хэрэгжүүлснээр жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

87.Дотоод аяллыг хөгжүүлэх зорилгоор Өргөөтийн рашаан, Өхөгийн амралт, Галуутын хавцал, Заг Байдрагийн Хүрэн бэлчир, Биндэръяа Хөх нуур, Гурванбулагийн Хөх нуур, Баянбүрдний байгалийн цогцолбор, Бөөнцагаан нуур, Орог нуур, Эрхэт, Тамчийн хавцал гэх мэт байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газруудаа түшиглэн аялал жуулчлалын баазуудыг байгуулна.

88.Сум бүр аялалын маршрут, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болж аймгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдох, “Хот айл-жуулчны бааз” төсөл хэрэгжүүлж малчин өрхүүд жуулчин хүлээн авч, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

89.Амралт аялал жуулчлалын 3 бүс цогцолборыг иж бүрэн тохижуулж, Баянхонгор сумын багууд, сум бүрт амралт, чөлөөт цагийн шинэ орчин бүрдүүлнэ.

90.БНХАУ-ын Альшаа аймгийн Эзнээ хошуунд болдог Тооройн баярт ирдэг жуулчдыг татах зорилгоор хил орчмын аялалын маршрутыг бий болгож, Мазаалай баавгайг аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн болгоно.

ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилго: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг тогтвортой нэмэгдүүлэх зарчим баримталж, таваарлаг мал сүрэгтэй, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлж иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлнэ.

91.Иргэдээ аймгийнхаа нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн төмс хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн, талх нарийн боов, жимс жимсгэнээр хангах “Органик хүнс” төсөл хэрэгжүүлнэ.

92.Арьс шир, ноосны урамшууллыг худалдан авах үед нь шууд олгодог байх саналыг холбогдох газруудад уламжилж шийдвэрлүүлнэ.

93. Мал аж ахуйг болон малын бэлчээрийг эрсдлээс хамгаалах төсөл хөтөлбөрүүдийг ОУ-ын байгууллагаудтай хамтран малчдын бүлэг, хоршоогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

94. Өндөр ашиг шимт шилмэл хээлтүүлэгчээс бүрдсэн **“Төрийн торгон сүрэг”** төслийг сум, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж, малын үүлдэр угсааг системтэйгээр сайжруулах арга хэмжээ авна.

95. Нутгийн шилмэл омог, үүлдэрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэнд оруулж, таваарлаг чанарыг нь сайжруулна.

96. Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх дунд хугацааны хөгжлийн стратеги бодлогын баримт бичигт туссаны дагуу аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт өндөр ашиг шимтэй, мах сүү, гахай, тахианы чиглэлийн фермерийн аж ахуйг хөгжүүлэх, тэдгээрийг тэтгэсэн малын тэжээлийн ургамал тариалах, тэжээл үйлдвэрлэх бодлогыг кластрийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлнэ.

97. Сум бүрт эмчилгээ тэжээлийн болон мал бордох цэгийг бизнесийн зарчмаар байгуулах асуудлыг бодлогоор хэрэгжүүлнэ.

98. Өндөр ашиг шимтэй таваарлаг аж ахуй эрхэлсэн малчдыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.

99. Томоохон голуудын голдрилд тохируулга, усны хуваарилалт хийх аргаар бэлчээр усжуулж, тэжээлийн ургамал тариалан усалгаатай талбайг нэмэгдүүлэх, бололцоотой газруудад хөв, цөөрмийг байгуулна.

100. Жил бүр 50-иас доошгүй газар уст цэгийн хайгуул хийж, 20-иос доошгүй гүн эрмийн худаг гаргаж, гар худаг гаргаж буй иргэдийг төрийн бодлогоор дэмжинэ.

101. Бэлчээрийн хортон мэрэгч устгах ажлыг судалгаанд үндэслэн дэвшилтэт арга технологиор тасралтгүй зохион байгуулна.

102. **“Монгол мал”** хөтөлбөрийг сэргээн эрчимжүүлж, ХАА-н биржийн сүлжээний гажуудлыг засах замаар, орон нутгийн онцлогт тохирсон биржийн тогтсолцоог аймаг, сум багийн түвшинд бий болгож, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн (арьс шир, ноос ноолуур, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн)-ний үнийг өсгөж, тогтвортой байлгах бодлого хэрэгжүүлнэ.

103. Малын халдварт өвчний тархалт, давтамжийн судалгааг үндэслэн мал эмнэлгийн цогц арга хэмжээг эрчимжүүлэх, түүхий эд бүтээгдэхүүний баталгаажилтыг хангах, нэгдсэн лабораторийг байгуулж, явуулын болон мал

эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээг өргөжүүлэх замаар **“Эрүүл бүс-эрүүл хүнс”** төслийг хэрэгжүүлнэ.

104. Малчдын залуу халааг бэлтгэх **“Илгээлтийн эзэн”** хөтөлбөрийг хэрэгжүүлж малжуулах төслөөр дэмжинэ.

105. *Аймгийн хэмжээнд малын эрүүл мэндийг хамгаалах асуудлыг нэн тэргүүнд тавьж, мал эмнэлгийн үйлчилгээнд тавих хяналтыг чангатгана.*

106. Баянхонгор аймгийн хөрсөнд нутагшсан хүнсний ногоо, малын тэжээлийн ургамлын сайн чанарын үрийн сан бүрдүүлж, услалтын системүүдийг нэмэгдүүлэн, 100 хувь ашиглаж хүнсний ногоо, малын тэжээл, эмийн ургамал тариална.

107. Газар тариалан эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, зах зээлийг нь хамгаалах бодлого хэрэгжүүлж, өвөл зуны хүлэмж бүхий агропарк байгуулан нарийн ногоо, жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалах, үр, хүнсний ногооны өндөр технологи бүхий зоорь байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

108. Байгаль хамгаалах асуудлыг бүх нийтийн үйлс болгох, оршин амьдарч буй газар нутгаа байгаль хамгаалах нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалттайгаар иргэд өөрсдөө байнгын хамгаалалтад авч, байгалийн дагалдах баялгийн үр шимийг зүй зохистой хүртэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

109. **“Ногоон Баянхонгор”** хөтөлбөр хэрэгжүүлж цөлжилтөөс хамгаалах хэсэгчилсэн ойн зурвасыг байгуулж, төв, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

110. Гол, горхи, булаг, шандны эх, гүний худгуудын хамгаалалтын бүсэд болон цөлжилт, элсний нүүдэлд автаж хөрсний элэгдэлд орсон газруудад амьдрах чадвартай заг, тоорой, сухай, хайлаас зэрэг мод болон харгана, торлог, тэсэг, шавга, шар мод зэрэг бутлаг ургамлуудыг тарьж ногоон хэрмийг бий болгох, Түй, Байдраг, Шаргалжуут, Цагаан туруут зэрэг томоохон голуудын ай савын дагуу мод тарьж ойн сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.

111. Иргэддээ **“экологийн боловсрол”** олгох, айл өрх, албан байгууллагын хашаа, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон, суурин газруудыг ногоон бүс болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байгаа байгууллага, өрх, иргэдийг урамшуулах, иргэд, нөхөрлөл, бүлгүүдийн тарьсан тарьц, суулгацыг худалдан авч дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

112.Ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас болж эвдэгдсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг зөвхөн орон нутгийн харъяат, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн оролцоотойгоор 100 хувь хийлгүүлнэ.

113.Ашиглагдахгүй байгаа бэлчээр нутагт хөв, цөөрөм байгуулах, ойжуулалт хийх, нөөцийг хамгаалах, зохистой ашиглахад малчдын бүлэг, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийг өргөнөөр оролцуулж тэдгээрийг чадавхжуулахын зэрэгцээ мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж хамтран ажиллана.

114.Утаагүй түлшний үйлдвэрлэл эрхлэх аж ахуй нэгж, иргэдийг дэмжинэ.

115.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжтэй гурван талт гэрээ байгуулах замаар бичил уурхай эрхлэгчдийн газрын асуудлыг шийдвэрлэж ажлын байр бий болгоно.

116.Сум бүрт хог боловсруулах жижиг үйлдвэр байгуулж, хоёрдогч түүхий эдийг ашиглах, байгаль экологид ээлтэй цаасан уут, сав баглаа босдлын болон даавуун уутны жижиг үйлдвэрлэл бий болгож гялгар,нийлэг уутны хэрэглээг хална.

117.Орон нутгийн шүтээн болсон уул усыг улс, аймгийн тусгай хамгаалалтанд авч, хангай нурууны 2 дахь ноён оргил Эрхэт хайрханыг аймгийн тахилгатай болгон, Их Богд хайрханыг Төрийн тахилгат уул болгох асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлнэ.

118.Нэн ховор болон ховордсон амьтан, ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ.ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилго: Үйлдвэрлэл, үйлчилгээг тэтгэсэн, иргэдийнхээ эрэлтэд нийцсэн дэд бүтцийг бий болгоно.

119.Аймгийн төвд Дулааны станц барьж агаарын бохирдол, утааны асуудлыг багасгахын зэрэгцээ хэрэглээний халуун усны төвлөрсөн системтэй болж, хуучирсан инженерийн шугамыг шинэчлэх, өргөтөх, инженерийн шугам тавигдсан 3; 6; 7; 9 дүгээр багуудын айл өрхүүдийг холбоно.

120.Баянхонгор сумын цэвэрлэх байгууламжид хэт ягаан туяаны цэвэршүүлэгч суурилуулна.

121.Баянхонгор сумын орон сууцны хуучин барилгуудыг буулгаж шинээр барих, өнгө үзэмжийг сайжруулах, гадна орчны тохижилт хийх, инженерийн шугамыг шинэчлэх төсөл хэрэгжүүлэн оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, үйлчилгээг СЭХ-д шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

122.Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, эдлэн газар бүхий Хаус хорооллыг шинээр байгуулж, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон **“Амины орон сууц”** хөтөлбөрийг дэмжинэ.

123.Стандартын шаардлага хангасан байнгын ашиглалттай усан сангуудыг төвлөрсөн шугаманд холбож холбогдох мэргэжлийн байгууллагад нь харъяалуулна.

124.Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг хэрэгцээ, шаардлагын дагуу нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчээр хангах, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станц шинээр байгуулан албан байгууллага, айл өрхүүдийг шөнийн тарифийн тоолуурт шилжүүлж цахилгаан халаагуур хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

125.“Баянхонгор Эрчим хүч” ХХК-ийг аворийн дизель станцтай болох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

126.Баянхонгор сумд нийтлийн тээврийн үйлчилгээний зориулалттай **“Эко автобус”** явуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадууд, хүүхдүүдэд хөнгөлөлттэй тарифаар үйлчилнэ.

127.Баянхонгор сумд авто вокзал барьж, хот хоорондын зорчигч тээвэрт унтлагын автобусаар үйлчлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

128.Баянхонгор-Бууцагаан чиглэлийн 129 км, Баянхонгор-Шаргалжуутын чиглэлийн 60 км, улсын чанартай, хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтанд оруулж, Баянхонгор- Баянлиг чиглэлийн босоо тэнхлэгийн замын ажлыг эхлүүлэн, Баянлиг-Гурвантэс чиглэлийн 293 км, Баянхонгор-Баянбулаг чиглэлийн 237 км хатуу хучилттай авто замын зураг төсвийг хийж барилгын ажлыг эхлүүлэх нөхцлийг бүрдүүлэх.

129.Баянхонгор-Эрдэнэцогт-Архангай чиглэлийн орон нутгийн чанартай авто замуудыг барьж, Цагаан туруутын голд төмөр бетон гүүр барьж, Өртөмт, Хүрэмтийн голын гүүрийг шинэчлэн засварлана.

130.Хоолтын гарамд гүүр барих асуудлыг судлан шийдвэрлүүлнэ.

131.Баянхонгор сумын Эрдэнэмандал 2, Цахир 7, Есөнбулаг 9 дүгээр багийн хатуу хучилттай замын асуудлыг цогцоор шийднэ.

132.Аймгийн төвд үерийн усны хамгаалалтын зураг төсвийг хийлгэж, барьж ашиглалтанд оруулна.

133.Өндөр хүчдэлд ойрхон багийн төвүүдийг эрчим хүчний шугаманд холбоно.

134.Шинэ зууны хөгжлийн чиг хандлага, технологийн дэвшил, иргэдийн хүсэл шаардлага, бизнесийн орчны өөрчлөлт зэргийг оновчтой шийдвэрлэж байх соёлтой шуурхай үйлчилгээтэй, технологижсон, ажиллаж амьдрахад таатай, аюулгүй ухаалаг аймгийг бий болгоход чиглэгдсэн **“Ухаалаг -Баянхонгор”** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

135.Өндөр хурдны шилэн кабелийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар бизнесийн шинэ боломжуудыг орон нутагт бий болгож зах зээлийн мэдээллийн орон зайн зааг ялгааг арилган мэдээллийн хурдыг сайжруулах, **“Цахим Монгол”** хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернэт хөтөлбөрийг зохион байгуулж, бүх сумдын төвд интернэт мэдээллийн төв ажиллуулна.

136.Баянлиг, Баянговь сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбож, суурин газруудад Wi Fi орчин бүрдүүлнэ.

137.Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөж аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд гар утсаар ярих боломжийг нэмэгдүүлж, Аймаг болон сумдын төвүүдэд утасгүй интернэт орчинг бүрдүүлэн, ДДэшТВ компанитай хамтран орсон нутгийн телевиз, радиогийн эфирийн цацалтын хүрээг тэлнэ.

138.Сумын төвүүдийг инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй болгох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны нэгдсэн системийг нэвтрүүлнэ.

139.Аймаг, сумдын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй өрхийг орсон сууцаар хангаж, нийгмийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн **“Түрээсийн орон сууц”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ТАВ. ЗАСАГЛАЛ, ГАДААД ХАРИЛЦАА, НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО

Зорилго: Авлигаас ангид, нээлттэй, ил тод, улс төрөөс ангид, шударга ёс, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёсыг эрхэмлэж ард түмнээ дээдэлсэн, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангасан, мэргэшсэн, хариуцлагатай ардчилсан төрт ёсыг бэхжүүлнэ.

140.Төрийн албанд намуудын улс төрийн томилгоогоор биш тухайн албанд ажилласан жил, дадлага туршлага ажлын гүйцэтгэлийн ур чадвараар нь шат дарааллан дэвшүүлдэг шударга зарчмыг хэрэгжүүлнэ.

141.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу аймгийн бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинэчлэн, иргэдийн санал, газар зүйн байршил, хүн

амын тоо, эдийн засгийн чадавхийг харгалзан нийгмийн үйлчилгээ, зах зээлийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх асуудлыг эн тэргүүнд тавьж шийдвэрлэх бодлого баримтална.

142. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн байгууллагуудыг хариуцлагатай, бодлого, судалгаанд тулгуурлан бодлого боловсруулж үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг, уян хатан, чадавхтай, өндөр бүтээмжтэй, хүнд сурталгүй, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан, иргэдээ нийгмийн сайн сайханд хөтөлсөн хөдөлгөгч хүч байхаар хөгжүүлнэ.

143. Төрийн албанд ажиллагсдыг гадаад, дотоодын их дээд сургууль ижил төстэй мэргэжлийн байгууллагуудад сургаж дадлагажуулан, төрийн мэргэшсэн албан хаагчдыг бий болгож хөгжүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий **“Төрийн мэргэшсэн албан хаагч”** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

144. Төрийн байгууллагуудад хэрэгжиж буй “Е-оффис” программын ашиглалтыг сайжруулж, цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, төрийн албаны нээлттэй ил тод шуурхай байдлыг хангасан технологижсон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг бий болгоно.

145. Шаардлагатай сумдад нутгийн удирдлагын ордон, багийн төвүүдийг шинээр барих, засварлах, өргөтгөх асуудлыг шийдвэрлэж засаг захиргааны анхан шатны нэгжид төрийн үйлчилгээг төвлөрүүлэх арга хэмжээ авна.

146. Аймгийн төрийн архивт аюулгүй байдлын баталгаа бүхий зориулалтын тусгай байр барьж ашиглалтад оруулна.

147. Шаардлагатай төрийн байгууллагуудад автомашин, мотоциклийн парк шинэчлэлт хийнэ.

148. Хууль тогтоомжинд иргэдийн саналыг тусгуулах, амьдралд ойр, хэрэгжих баталгаатай хууль санаачлахад нь УИХ-ын гишүүдтэй хамтран ажиглаж, **“Иргэний санал- Их хуралд”** төслийг хэрэгжүүлнэ.

149. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, авлига хүнд сурталтай тэмцэж шударга бус зүйлийг үл тэвчих зорилтыг эн тэргүүнд тавина.

150. Иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилго бүхий **“Амар тайван”** амьдрал хөтөлбөр хэрэгжүүлнэ.

151. Гамшигийн үеийн бэлэн байдлыг сайжруулж, эрсдлээс хамгаалах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

152. Аймгийн хөгжилд төр хувийн хэвшлийн зохистой харьцааг бүрдүүлэх, оролцооны тэгш байдлыг хангах, хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

“Баянхонгор хөгжлийн корпораци” ХХК-ыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулан, үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангана.

153.Монгол Улсын гадаад бодлогд нийцүүлэн аймгийн гадаад харилцааг эдийн засагжуулах, иргэдийн хөгжлийг хангах, уламжлалыг сэргээх чиглэлээр харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогыг тууштай баримтална.

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ҮР ДҮНГ ИЛЭРХИЙЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хөгжүүлэх хэтийн зорилтыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжилд гарах үр дүн, өөрчлөлтийг дараах №19 үндсэн үзүүлэлтээр бусад аймгуудтай харьцуулж тодорхойллоо.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014 он)	Зорилтот түвшин (2020 он)	Хүрэх түвшин (2025 он)
1	Аймагт үйлдвэрлэсэн ДНБ	сая төгрөг	331 491,4 12-р байр	678294,0 9-р байр	1200 000,0 5-р байр
2	Хүний хөгжлийн үзүүлэлт (индекс)	эзлэх байраар	0,666 19-р байр	0,776 15-р байр	0,935 9-р байр
3	Дундаж наслалт	насаар	68,89 17-р байр	71,33 12-р байр	75,00 5-р байр
4	Ядуурлын түвшин /эжилгүйдлийн түвшин	хувиар	5,6 7-р байр	4,0 5-р байр	2,0 3-р байр
5	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	эзлэх байраар	46,88 20-р байр	64,16 14-р байр	90,00 5-р байр
6	Эдийн засгийн тамир тэнхээ	эзлэх байраар	39,03 16-р байр	53,37 11-р байр	74,89 5-р байр
7	Засаглалын үр ашиг	эзлэх байраар	43,68 18-р байр	59,74 13-р байр	83,82 6-р байр
8	Бизнесийн үр ашиг	эзлэх байраар	51,97 14-р байр	71,06 9-р байр	99,7 3-р байр
9	Дэд бүтэц	эзлэх байраар	42,93 18-р байр	58,71 13-р байр	82,38 6-р байр
10	Нийгмийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувь	хувиар	69,0 18-р байр	81,0 13-р байр	99,0 5-р байр
11	1000 амьд төрөлт дэх нялхсын эндэгдлийн түвшин	промилээр	15,1 8-р байр	13,86 6-р байр	12,0 4-р байр
12	100000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн түвшин	промилээр	137,4 21-р байр	8-р байр	Эхийн эндэгдэлгүй аймаг болно
13	Сургуулийн эмнэх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт	хувиар	6320,0 85 хувь	100%	90 хувьд Хүргэнэ
14	Баянхонгор аймагт аялах гадаадын жуулчдын тоо	мян хүн	3000	6000	10000
15	Нийт экспортод боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь	хувиар	0%	4%	10%
16	ДНБ-нд боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	хувиар	2,7 12-р байр	6 9-р байр	10,0 5-р байр
17	Төмс, хүнсний ногоогоос дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах	хувиар	Төмс-62,0 % Хүнсний ногоо- 34,0%	77,2% 60,4%	Төмс-100,0 % Хүнсний ногоо-100,0%
18	Малын тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээ	1 малд ногдох хэмжээгээр	0,2%	6,4%	10%
19	Ногоон байгууламжийн хэмжээ	га	90,0	34	200,0